



**ТӨВ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/186.

Зуунмод сум

**Зардал гаргах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн эмч нарын өдрийг тохиолдуулан, аймгийн Эрүүл мэндийн салбарын чадавхыг бэхжүүлэх, нотолгоонд суурилсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, шинэлэг арга зүй, туршлагаа хуваалцах зорилгоор зохион байгуулж буй онол практикийн бага хуралд амжилттай оролцсон эмч, мэргэжилтнүүдийг шалгаруулан, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсугай.

2. Шалгарсан эмч, мэргэжилтнүүдийн шагнал урамшууллын зардалд шаардагдах 1,200,000 (нэг сая хоёр зуун мянга) төгрөгийг Төсвийн хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т, нилэн дансанд байршуулж ажиллахыг аймгийн Төсвийн ерөнхий нягтлан бодогч (Б.Одончимэг)-д тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Мөнхцэцэг)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР